



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/708

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Хууль зүйн сайдын 2015 оны А/224 дүгээр тушаалаар батлагдсан “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”-ийн 2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 4.2.18.122 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн архивын байрны галын аюулгүй байдлыг хангах, цахилгааны щитийг орчин үеийн стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх зорилгоор дотор цахилгааны засварын зардалд 783480 (долоон зуун наян гурван мянга дөрвөн зуун наян) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 783480 (долоон зуун наян гурван мянга дөрвөн зуун наян) төгрөгийг аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101347